



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/13

Тавин

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт, Улсын тэмдэгтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувиараа хөдөлмөр эрхлэгч В.Ганхөлөг /ЗЮ73120418/-т тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийг олгоход хураах тэмдэгтийн хураамж 250000 /хоёр зуун тавин мянган/ төгрөгийг Орон нутгийн орлогод төвлөрүүлж, дээрх хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын улсын байцаагч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ

(D)/ZDTG2021/захирамж.docx

481210139